



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 1/62

Хужирт сум

Г
Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар
тахлын тархалттай холбогдуулан авах
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 91 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын тархалттай холбогдуулан авах арга хэмжээний тухай” А/174 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн итгээдийг 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 06⁰⁰ цагаас 4 дүгээр сарын 25-ны өдрийн 06⁰⁰ цаг хүртэл Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.
2. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараах хязгаарлалтуудыг тогтоосугай.
 - a. Эм, эмийн хэрэгсэл, хүнс, түлш, шатахууны, малын өвс тэжээлийн тээврээс бусад сумын нутаг дэвсгэрээс гарах болон орох тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг дээрх хугацаанд зогсоох;
 - b. Эрүүл мэндийн тусlamж авах болон буяны ажилтай иргэд сумын Шуурхай штабаас зөвшөөрөл авч зорчих;
 - c. Тусгай чиг үүргийн байгууллага, эрүүл мэндийн төв, эмийн сан, шатахуун түгээх станц, уст цэгээс бусад төрийн болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр хориглох;
 - d. Архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 06.00 цаг хүртэл хориглох;

f. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх зорилгоор цахимаар хичээллүүлэх;

3. Банкуудыг 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн зөвхөн дотоод үйл ажиллагааг явуулахыг зөвшөөрч, Захиалгаар ирсэн иргэдийн картыг олгох, шинээр захиалах картны захиалгыг иргэдээс утсаар авах ажлуудыг зохион байгуулж ажиллахыг банкны эрхлэгч нарт даалгасугай.

4. Иргэдэд гэртээ хийх ариутгал халдвартгүйжүүлэлтийн талаар заавар, зөвлөгөөг тогтмол өгч байхыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Э.Оюунпүрэв)-д үүрэг болгосугай.

5. Бүх төрлийн хүнсний болон бараа бүтээгдэхүүнд зохиомол үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байхыг худалдаа, бизнес эрхлэгчдэд үүрэг болгосугай.

6. Үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, газруудад (Эрүүл мэндийн төв, шатахуун түгээх станц, эмийн сан, уст цэг, хүнсний түгээлт) хяналтын системийг тогтмол хөтлүүлж, эрүүл ахуй, халдварт хамгааллын дэглэм, ариутгал халдвартгүйжүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэцэгмаа, Мал эмнэлийгийн тасгийн Улсын байцаагч Б.Ичинхоролцэвэлмаа нарт даалгасугай.

7. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМОНХ